



2024 ОНЫ 12 САРЫН 1

# НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХУРААНГУЙ

ТННЭ НООС НООЛУУРЫН СТАНДАРТ



ТОГВОРТОЙ НООС НООЛУУРЫН ЭВСЭЛ

## Зорилт, хамрах хүрээ

Энэхүү баримт бичигт 2023-2024 оны хооронд явагдсан ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарын хэлэлцүүлэг, гарсан үр дүнгийн талаар доорх дарааллаар танилцуулав:

- ТННЭ Ноолуурын Стандартыг хянан сайжруулах үндэслэл;
- Хянан сайжруулалтын үр дүн (Нэмэлт, өөрчлөлтийн хураангуй);
- Оролцогч талуудын оролцоо.

Стратегийн ойлголт, ухагдахууныг сайтар ойлгуулах, харилцан зөвшилцөл, итгэл үнэмшлийг бий болгоход бодит, шударга, оролцоог эрхэмлэх нь ТННЭ-ийн хэлэлцүүлгийн гол зорилго оршино. Бидний баримталдаг зарчим бол нээлттэй хэлэлцүүлэг нь бидний зорилгодоо хүрэхэд туслах арга зам байхаас гадна оролцогч талуудад тэдний санал, сэтгэгдэл чухал болохыг ойлгуулдаг байх явдал юм. ТННЭ-ийн хэлэлцүүлгийн процесс нь [ТННЭ Стандарт Тохируулах Журамд](#) тусгагдсаны дагуу [ОУНБОМИШХ \(ISEAL\) Стандарт Тохируулах Сайн Туршлагын Кодыг](#) мөрдлөг болгодог.

ОУНБОМИШХ нь бүх оролцогч талуудын оролцоог нээлттэй байлгахыг шаарддаг ба стандарт боловсруулагчийн зүгээс зарим шаардлагатай оролцогч бүлгүүдээс оролцоотой байхыг хүсэмжлэх, дэмждэг байхыг шаарддаг. Үүний зорилго нь тухайн асуудал дагуулсан сэдэв болоод түүнд харгалзах газар нутагт оролцогч талуудын үзэл сонирхлын түвшнийг тэнцвэртэй байлгахад оршино.



**CLICK HERE TO  
GET CERTIFIED NOW**

# ЯАГААД СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭХ БОЛОВ?

## Үндэслэл

Баталгаажсан ноолуурын зах зээлд ТННЭ Ноолуурын Стандарт хамгийн том байр суурийг эзэлдэг. Тус стандарт нь үр дүнтэй удирдлагын систем, найдвартай мөшгөлтийн тогтолцоонд суурилан ямааны тавлаг байдлыг нэмэгдүүлэх, биологийн олон янз байдал ба газар орныг хамгаалах, зохистой ажил эрхлэлтийг дэмжих, ноос ноолуурын чанарыг сайжруулахад чиглэгдсэн цор ганц стандарт юм.

ТННЭ Ноолуурын Стандартын [анхны хувилбар](#) нь 2022 онд хийсэн хянан сайжруулалт, оролцогч талуудын дунд явагдсан хэлэлцүүлгийн үр дүнд шинэчлэгдэж 2023 оны 1-р сард нийтлэгдсэн. Стандартын анхны хувилбарыг хэрхэн боловсруулсан талаар, мөн ирүүлсэн санал, сэтгэгдлүүдтэй уншиж танилцах бол [энд](#) дарна уу. Тус ажлын гол зорилт нь үндэсний хэмжээний стандартуудыг глобал түвшинд нэгтгэж, зохистой ажил эрхлэлт болон ноос ноолуурын чанарыг сайжруулах шалгууруудыг нэмж оруулах байв.

## Хэлэлцүүлэг

ТННЭ Ноолуурын Стандартын анхны хувилбар нийтлэгдсэний дараачаар зарим оролцогч талууд асуудал дэвшүүлсэн. Үүнд амьтдын тавлаг байдалд тавигдах шаардлагууд нь өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдийн хүлээлттэй нийцэхгүй байх тухай онцолсон. Энэ нь одоогийн ОУНБОМИШХ Сайн Туршлагын Кодын заалт 6.5 бүрэлдэх эхлэлийг тавьсан юм. Үүнд *“Чухал ач холбогдолтой гэж үзсэн тохиолдолд бүрэн шийдэгдээгүй байгаа асуудлууд дээр [...] баримт бичиг эзэмшигч нь нэмэлтээр олон нийтэд чиглэсэн эсвэл тодорхой зорилтот бүлэгт хандсан хэлэлцүүлгийг зохион байгуулна”* гэж тусгагдсан.

## Зохих арга хэмжээ, үр дүн

Дээр дурдсан шалтгаанаар ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбарт дахин шинэчлэлт хийх хугацааг дараачийн хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж дуусах хүртэл сунгахаар шийдсэн. Түүнээс хойш олон тооны санал, хүсэлт хүлээн авсан ба шинэ [ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарыг](#) боловсруулахад тэдгээр ирүүлсэн санал тус бүрийг хэлэлцэж, нягтлав. Тус стандарт нь 2024 оны 12-р сард нийтлэгдсэн.

Энэхүү баримт бичигт тайлбарлах стандартын загвар, агуулгатай хамааралгүй боловч ТННЭ-ээс санаачлан хэрэгжүүлдэг бусад хөтөлбөртэй холбоотой аливаа асуудал, санал сэтгэгдлийг [ТННЭ Нээлттэй Хэлэлцүүлгийн Портал](#)аар дамжуулж илгээнэ үү.



**CLICK HERE TO  
GET CERTIFIED NOW**

## Үр дүн

Шинэчилсэн “ТННЭ Ноос Ноолуурын Стандарт” нь “ТННЭ Ноолуурын Стандарт”-ын 1.0 хувилбарыг орлох баримт бичиг мөн болно. Энэ бүлэгт ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбар нь шинэчилсэн стандартаас ямар ялгаатай болох, хассан заалтууд болон хэлэлцүүлгийн явцад хүлээж авсан санал хүсэлтэд үндэслэн ямар ямар өөрчлөлтүүдийг оруулсан талаар дурдав. Хамгийн эхэнд хэлэлцүүлгийн үр дүнд орсон өөрчлөлтүүдийг танилцуулна. Бусад санал, хүсэлтийн хураангуйг Хавсралт 1: Оролцогч талуудын оролцооны тайлангаас харах боломжтой. Шинэчилсэн стандартын агуулга, хэрхэн ашиглах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [ТННЭ Баримт бичиг](#) вэб хуудаснаас авна уу.

Шинэчилсэн стандарт нь бусад малын ноос ноолуурыг хамруулахаар боловсруулагдсан. Гэхдээ одоо танилцуулж буй хувилбарт зөвхөн ямааны ноолуурыг авч үзсэн. Ойлгомжтой байлгах үүднээс шинэ стандартад ашиглагдсан “малын ноос ноолуур”, “ноос ноолуурын мал” гэсэн хэллэгүүдийг энэхүү баримт бичигт “ноолуур”, “ямаа” гэсэн нэршлээр орлуулав.

## Нэмэлт, өөрчлөлтийн хураангуй

### Мал төхөөрөхийн өмнөх цохиж ухаан балартуулах процесстой холбоотой засаж, сайжруулсан шаардлагууд

Төхөөрөх гэж буй малыг зохистой багаж хэрэгсэл ашиглан ухаан балартуулах нь тавлаг байдлыг нь хангаж буй нэг хэлбэр юм. Хэлэлцүүлгийн явцад бүх малыг төхөөрөхөөс нь өмнө ухаан балартуулах шаардлагатай тухай асуудал, саналууд гарсан. Цаашилбал, а) малыг ухаан балартуулахад уламжлалт арга барил ашиглахын оронд зүй зохисгүй багаж хэрэгсэл ашиглаж, туршлагагүй хүнээр гүйцэтгүүлэх нь малд маш муу үр дагавар авчирч болно; б) орон нутгийн ажилчид, малчин өрхийг өөрсдийн гэсэн мал төхөөрөх багаж хэрэгсэлтэй байхыг, түүнийгээ арчиж тордохыг шаардах нь хүүхдүүдэд эрсдэл учруулж байна гэсэн асуудлууд дэвшигдсэн. Энэ мэт асуудлыг арилгах үүднээс одоо байгаа шалгуурууд дээр нэмж ТННЭ-ийн зүгээс дараах шаардлагуудыг хэрэгжүүлж байна. Ингэснээр ноос ноолуурын малын хувьд, ялангуяа олноор нь төхөөрч байх тохиолдолд өвдөлт, зовуурь, түгшүүрийг бага түвшинд байлгаж, дадал болсон уламжлалт аргыг ашиглахын оронд өрх гэртээ багаж хэрэгсэл авчрах, эсвэл буруу ашиглахтай холбоотой асуудалд тэнцвэрт байдал бий болгоно гэдэгт итгэж байна. Түүнчлэн малыг тухайн нөхцөлд нь тохируулан ухаан балартуулахыг нэг сайжруулах үзүүлэлт болно гэж үзэхээр тусгасан.

- 18.1 Мал амьтад нь шим тэжээлийнхээ дийлэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг тохиолдолд, нэгээс олон мал нэг дор нядалгаанд орж байгаа тохиолдолд, мөн малын тоо толгойг багасгах эсвэл худалдааны мах үйлдвэрлэлийн зорилгоор малыг нядалж байгаа бол биет байршил нь малыг төхөөрөхдөө нядалгааны явцад мал мэдээ орж, сэрэхээргүй байхаар хурдан хугацаанд ухаан балартуулах арга ашиглах **ёстой**.
  - 18.1.1 Биет байршил нь малыг төхөөрөхөөс өмнө малыг нядалгааны явцад мал мэдээ орж, сэрэхээргүй байхаар хурдан хугацаанд ухаан балартуулж **болно**.
- 18.2 Биет байршил нь мал төхөөрөхөд ямар арга ашиглахаас үл хамааран малыг зөвхөн цэвэрхэн, зориулалтын багажаар, туршлагатай хүнээр төхөөрүүлэх **ёстой**.
- 18.3 Биет байршил нь мал төхөөрөхөд ямар арга ашиглахаас үл хамааран малыг найдвартай хурдан, үр дүнтэй төхөөрөхөд анхаарах **ёстой**.

- 18.4 Биет байршил нь төхөөрөх гэж буй малыг төхөөрөх хүртэл нь төхөөрөх гэж буйг мэдэгдэхгүй байх **ёстой**.
- 18.5 Биет байршил нь ойр хавьд төхөөрсөн бусад амьтдыг өөрийн мал сүрэгтээ мэдэгдэхгүй байх **ёстой**.
- *Энэ нь тухайн мал өөрийг нь төхөөрөх хүртэл бусад амьтдыг төхөөрч байхыг харах, сонсох эсвэл үнэрлэх боломжгүй байх ёстой гэсэн үг. Ингэснээр төхөөрөх гэж буй мал тайван байж, айдас түгшүүргүй байх юм.*
- 18.6 Биет байршил нь малыг гадаад улсад төхөөрөх зориулалтаар худалдахгүй байх **ёстой**.

## Тогтмол сайжруулалтыг үнэлэх шинэчилсэн систем

Ноолуур үйлдвэрлэлд хяналт тавихад ашиглагддаг ТННЭ-ийн зохистой дадлын код нь тогтмол сайжруулалтыг үнэлэх үнэлгээнд медалийн систем (алтан медаль, мөнгөн медаль, хүрэл медаль) ашигладаг байсан. Үүнийг ТННЭ Ноолуурын Стандарттай нэгтгэснээр тэнцсэн эсвэл тэнцээгүй гэсэн шинэ системийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд аж ахуйн нэгжүүд гэрчилгээ авахын тулд бүх шаардлагуудад тэнцсэн байх хэрэгтэй болсон. Энэ нь аж ахуйн нэгжийг ТННЭ-ээс хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдэд элсэхэд өндөр шалгуур болсон бөгөөд ТННЭ-ийн зүгээс хөтөлбөрүүддээ оролцуулах хүсэлтэй зарим аж ахуйн нэгжүүдийг оруулалгүй өнгөрөөх тохиолдлууд гарсан байх боломжтой. Хэлэлцүүлгийн үр дүнд доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зөв юм гэдэг санал хүчтэй дэмжигдсэн.

Шинэчилсэн стандартын 7-р бүлэгт аж ахуйн нэгжүүдийн хийж гүйцэтгэвэл зохих наад захын шаардлагуудыг нарийн тодорхойлж өгсөн ба “тогтмол сайжруулалт” хийгдсэн гэдгийг харуулах, нотлох шаардлага багтсан. Тодруулбал, “аж ахуйн нэгж/биет байршил нь ... ёстой/байх/на<sup>4</sup>” гэсэн хэсгүүд бүгд шаардлага болно. Мөн зарим шаардлага байсан заалтууд “сайжруулах үзүүлэлт” болж өөрчлөгдсөн ба тэдгээрийг “аж ахуйн нэгж/биет байршил нь ... болно” гэдгээр илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгж нь эдгээрийг “тогтмол сайжруулалт” хийдэг гэдгээ харуулах үүднээс биелүүлж болно гэсэн үг. Аж ахуйн нэгж нь бүх сайжруулах үзүүлэлтүүдийг биелүүлсэн тохиолдолд тогтмол сайжруулалтыг харуулсан байх шаардлагаас чөлөөлөгдөх ба өндөр гүйцэтгэл бүхий аж ахуй нэгжид олгодог нэр хүнд бүхий “ТННЭ Шилдэг Туршлага” өргөмжлөлийг авах хүсэлт гаргах боломжтой болно. Цаашилбал, эдгээр сайжруулах үзүүлэлтүүдийн зармыг нь аж үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдуулж бус өргөн цар хүрээтэй газар нутгийн байдалд суурилсан системд үндэслэн хангасанд тооцох боломжтой. Өөрөөр хэлбэл ТННЭ-ийн зүгээс сайшаалтай, дэмжлэг үзүүлэх боломжтой гэж тооцогдсон үйлдвэрлэлийн системд боломж олдоно гэсэн үг юм.

## Газар эзэмших эрхийг нотлох шинэ шаардлага

ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарын шинээр нэмэгдсэн шаардлага (8.1)-д биет байршил нь ашиглаж буй газартаа үйл ажиллагаа явуулах эрхтэй гэдгээ нотлох ёстой гэж заасан. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## Орон нутгийн хууль тогтоомж давуу эрхтэй байх шинэ заалт

Шинэчилсэн стандартад шинэ заалт (1.2) орж ирсэн. Үүнд, энэхүү стандартын шаардлага тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй улсын хуультай зөрчилдвөл тухайн улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийг нэн түрүүнд хэрэгжүүлнэ гэж тусгагдсан. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## **Үржилд орох хамгийн бага насны хязгаарыг тодорхой болгов**

ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарын заалт 23.2-т үржүүлэгт оруулах ямааны хамгийн бага насыг тодорхой болгож өгөв. Тухайлбал, эм төлийн хувьд 12 сараас доошгүй, эр төлийн хувьд 18 сараас доошгүй байна. Хэлэлцүүлгийн үр дүнд эр төлийн үржилд орох насыг 7 сараас доошгүй гэж заасан байсныг 18 сараас доошгүй болгож өөрчилсөн.

## **Нядалгаанд зөвхөн эйтанази буюу гол таслах арга барил ашиглах шаардлагыг хасав**

ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбарт дараах шаардлага багтсан байсныг үндэслэлгүй гэж дүгнэсэн тул хассан: зовууртай эсвэл өвдсөн, эдгэрэхээргүй, ямар нэг эмчилгээ үр нөлөөгүй, хроник буюу хэт их зовлон шаналалтай байгаа тохиолдолд л ямааны амийг тасална. Учир нь жижиг, хэрэгцээгээ л хангах зорилготой өрхийн хувьд малыг хувийн эсвэл худалдааны зорилгоор нядлах нь түгээмэл явдал байдаг. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## Хүнсний зориулалттай ямааны чанарт тавигдах шаардлагыг хасав

ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбарт дараах шаардлага тусгагдсан байдаг. “Хэрэв ямааг хүнсний зориулалттай ашиглах тохиолдолд амийг нь таслахаас урьдаж өмнө нь өгсөн эм, эмчилгээ, тарианы үр нөлөө ямааны биед байхгүй болсон гэдгийг малын эмчийн зааварчилгааны дагуу бататгах ёстой”. Энэ шаардлагыг ТННЭ Ноолуурын Стандартын хамрах хүрээнээс хальсан буюу Стандартын ажлын удирдамжид тусгагдсан таван зарчим болох биологийн олон янз байдал ба газар ашиглалт, зохистой хөдөлмөр эрхлэлт, малын тавлаг байдал, үр дүнтэй удирдлага, ноос ноолуурын чанарын сайжруулалтын алинд ч хамаарахгүй шаардлага гэж үзсэн тул хассан. Хэлэлцүүлгийн үр дүнд энэхүү шаардлага нь чухал шаардлага болохыг онцолсон боловч ТННЭ Ноолуурын Стандартын хамрах хүрээнээс хальсан асуудал мөн юм гэдэг дээр санал нэгдсэн болно.

## Аж ахуйн нэгжийг тодорхойлох шинэ шаардлагууд

Аж ахуйн нэгж болон тэдгээрийн биет байршлуудад тавигдах шинэ шаардлагуудыг Бүлэг 3: Аж ахуйн нэгжийн бүтэц-д оруулав. Тухайлбал хэн гэрчилгээ авч болох, мөн [ТННЭ Баталгааны гарын авлага](#)-н 28-р бүлэгт заасны дагуу аж ахуйн нэгжүүд болон тэдгээрийн биет байршлууд хэрхэн хамтдаа амжилттай байх эсвэл шаардлагад нийцэхгүй унах талаар тайлбарласан. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## Ажилчдын ур чадвар

ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбарт тусгагдсан олон шаардлагуудад вакцинжуулалт буюу эмийн эмчилгээ, мал хөнгөлөх зэрэг үйл ажиллагааг малын эмчийн зааварчилгааны дагуу явуулна гэж заасан. Эдгээр шаардлагуудын ихэнхийг нь сайжруулах үзүүлэлт болгосон боловч үйлдвэрлэгчийн хувьд Бүлэг 5: Аюул-д тусгагдсаныг наад захын шаардлага болгосон. Бидний зүгээс үйлдвэрлэгчид энэ шаардлагыг хангаж ажиллах боломжтой гэж үзсэн. Ингэхдээ дээр дурдсан үйл ажиллагааны явцад ямааны тавлаг байдлыг хангахыг дэмждэг ТННЭ-ийн зорилтыг санах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн үр дүнд сургалтад хамрагдах нь сайжруулах үзүүлэлт байхын оронд шаардлага байх ёстой талаар асуудлууд дэвшигдсэн. Энэ асуудлыг дараачийн удаа хийгдэх хяналт, үнэлгээндээ авч хэлэлцэх болно.

## Аж ахуйн нэгж ба биет байршлуудын тодорхойлолтод оруулсан тодруулгууд

ТННЭ Ноос Ноолуурын Стандартыг мөрдлөг болгосноор тохирлын гэрчилгээг эзэмшинэ. Тухайн гэрчилгээнд гэрчилгээний үйлчлэх хүрээнд хамаарах үйл ажиллагааны төрлүүдийг тодорхойлсон байна. Тохирлын гэрчилгээг ноолуур үйлдвэрлэлд хариуцлагатай оролцож буй нэг ба түүнээс олон биет байршлуудтай “аж ахуйн нэгж” эсвэл үйлдвэрлэгч байгууллага эсвэл ноос ноолуур худалдан авагч эзэмшинэ. Аж ахуйн нэгж болон түүний биет байршлууд нь ондоо байгууллага, хувь хүмүүс байж болох хэдий ч тус тохирлын гэрчилгээ нь тэднийг нэгэн цул болгож, хамтын хариуцлага хүлээх үүрэгтэй болгоно. Аж ахуйн нэгж ба түүний биет байршлууд нэг бол хамтдаа амжилттай байна эсвэл хамтдаа бүтэлгүйтнэ. Жишээлбэл, аль нэг биет байршил нь энэхүү стандартын шаардлагыг хангалгүй үл нийцэлтэй болох нь тогтоогдвол тухайн аж ахуйн нэгжийн бүх биет байршлууд нэгэн адил үл нийцэлтэй болно. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

[ТННЭ Баталгааны гарын авлага](#)-аас тохирлын гэрчилгээ болон үл нийцлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

## **Аж ахуйн нэгжүүд ба тэдгээрийн биет байршлуудын үүрэг хариуцлагын талаар хийгдсэн тодруулгууд**

Шаардлага, сайжруулах үзүүлэлт бүрд тус шаардлагыг биелүүлэх нь аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлага байх уу эсвэл биет байршлын үүрэг хариуцлага байх уу гэдгийг тодорхой тусгасан. Ингэснээр давхар хүчин чармайлт гаргах явдлыг арилгаж илүү хариуцлагатай байдалд хүргэнэ гэдэгт итгэлтэй байна. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэгж шүүмж гараагүй.



## Зарим биет байршлыг хамааралгүй шаардлагуудаас чөлөөлөх

Зохистой ажил эрхлэлттэй холбоотой шаардлагуудын заримыг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай түлхүү уялдуулсан. Иймд “ажил олгогч-ажилтан” харилцааг зохицуулах ажил эрхлэлттэй холбоотой шаардлагуудын заримыг нь нөхцөлтэйгөөр чөлөөлөх заалтыг оруулж өгөв. Энэ нь дотоод үйл ажиллагаатай онцын холбоогүй юм. Тухайлбал, биет байршилд ажиллаж буй ажилчид бүгд нэг гэр бүлийн гишүүд бол зарим шаардлагуудаас чөлөөлөгдөнө. Хэлэлцүүлгийн үр дүнд гэр бүл/малчин өрхүүд өөрсдөө зохисгүй ажил эрхлэх дадалд буруутай байж болох талаар асуудал дэвшигдсэн. Бидний зүгээс үүнийг асуудал болохгүй гэж үзэж байгаа боловч хяналттай ажиллах болно.

*Шинэчилсэн стандартын хүрээнд малчин өрхүүд ямар шаардлагаас чөлөөлөгдөх боломжтой талаар мэдэхийг хүсвэл “биет байршил” гэсэн түлхүүр үгийг ашиглана уу.*

## Тодорхой байдал

Стандартад тусгагдсан шаардлагуудын зарим нь абстракт буюу тодорхой бус, ямар нэг нөхцөлд баригдахгүй байх талтай нь анзаарагдсан. Эдгээр шаардлагуудыг хэвээр нь үлдээвэл ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг ч ондоо ТҮБ-аар дамжуулж тохирлын үнэлгээ хийлгэдэг аж ахуйн нэгжүүдэд үнэлгээний процесс нь ондоо байх, үр дүн тогтворгүй, зөрчилтэй байхад хүргэх юм. Иймд бидний зүгээс тодорхой бус үг хэллэг, томъёоллуудыг арилгах арга хэмжээг авсан ба бүх шаардлагуудаа илүү нарийн, тодорхой болгосон. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

Жишээ дурдвал:

- Сургалтад тавигдах мэдлэг, ойлголтын шаардлагууд. Харгалзах заалтуудыг стандартын 4-р бүлгээс харна уу.
- Бүртгэл хөтлөлт. Харгалзах заалтуудыг стандартын 6-р бүлгээс харна уу.
- ОУХБ ба НҮБ-ийн тодорхойлолтууд.

## Зарим заалтыг оновчлов

Давтагдсан болон хэрэгцээгүй шаардлагууд олшрох нь гэрчилгээ эзэмшигчийн аудитын төлбөрийг нэмэгдүүлж, зайлсхийж болох байтал ачаалал үүсэхэд хүргэдэг. Энэ удаагийн шинэчлэлээр бид стандартыг оновчлох боломжийг алдалгүй ашиглаж, зайлшгүй засваруудыг оруулав. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

Жишээ дурдвал:

- Аюултай материалын хэрэглээ ба устгал. Харгалзах заалтуудыг Бүлэг 5 ба 22, мөн 6.1 (а), 13.2 болон 13.3 хэсгүүдээс харах боломжтой.
- Усны эх үүсвэрийг хамгаалах. Харгалзах заалтуудыг 12.3, 12.4, 12.5 хэсгүүдээс харах боломжтой.
- Хариуцлагатай газар эзэмших эрх. Харгалзах заалтуудын Бүлэг 8 болон 6.1 (g) хэсгээс харах боломжтой.
- Тогтмол сайжруулалт. Харгалзах заалтуудыг Бүлэг 7-оос харна уу.
- Голын сав газар (дренаж) болон усархаг газруудыг элэгдэл, бохирдол, тунадасжилт үүсэхээс хамгаалахад зориулсан шаардлагуудыг нэгтгэв (12.3).

- Мал эзэмшигчийн малтайгаа харилцах харилцааг зохицуулах бүх шаардлагуудыг ганц шаардлагад нэгтгэсэн (14.1).
- Заалт 10.8.с -д тусгагдсан байсан “эсвэл асрагч эмэгтэй” гэснийг хассан. Энэ нь 10.9.b заалттай утга дүйнэ.
- Заалт 26.1-т тусгагдсан байсан “тавлаг байдал ба тухайн орчинд тохирсон байдал” гэснийг хассан. Энэ нь 23.1 заалттай утга дүйнэ.
- Аж ахуйн нэгжийн түвшний бүртгэл хөтлөлт, үнэлгээний шалгууруудыг нэгтгэсэн (Бүлэг 6).

## Үйлдвэрлэгч орнуудад зориулсан шинэ удирдамж

Шинэчилсэн стандартыг глобал түвшинд хэрэглэх зорилт тавьж боловсруулсан ба дэлхийн аль улсад байхаас үл хамааран бүх аж ахуйн нэгжүүдэд суурь шаардлагууд адил тавигдана. Гэхдээ үйл ажиллагаа явуулж буй газрын нөхцөл байдал стандартын шаардлагын бодит хэрэгжилтэд нөлөөлж болох тул ТННЭ-ийн зүгээс “Үйлдвэрлэгч орнуудад зориулсан удирдамж”-ын загварыг гаргав. Энэ нь стандартад тусгагдсан шаардлагуудыг аж ахуйн нэгжүүд болон ТҮБ нь үйл ажиллагаа явуулж буй улсдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар тайлбарласан туслах баримт бичиг юм. Шинэчилсэн стандартыг олон нийтэд танилцуулахтай зэрэгцэн Афганистан, Хятад, Монгол гэсэн улсуудад зориулсан удирдамжууд хамт нийтлэгдэхээр байна. Бусад улсуудад зориулсан удирдамжууд хэсэг хугацааны дараа нийтлэгдэх болно. Тус удирдамжуудад тусгагдсан асуудлуудын заримаас нь дурдвал:

- Ундны ус, цахилгаан, интернэт гэх зэрэг дэд бүтцээр хангагдах тухай;
- Аюулд өртсөн болон ондоо бүс нутгаас ирсэн төрөл зүйл гэх мэт орон нутгийн шинж чанартай экологийн нөхцөл байдал;
- Технологи, эм тариа, ноолуур авах арга барил хэрэглэх, тэдгээрт суралцах боломж, хүртээмж;
- Уугуул иргэдийн хамтарсан холбооны адил орон нутгийн иргэдийг оролцуулсан, хуулиар хамгаалагдсан нийгэмлэг;
- Бэлчээр зохион байгуулалтыг хэн хариуцах тухай тодорхойлолт;
- Тухайн улсад түгээмэл тохиолддог бусад эрсдэлүүд гэх мэт.

Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## Ирээдүйд тус стандартад бусад малын ноос ноолуурыг хамруулах боломжтой бүтцийн өөрчлөлт

Энэ удаагийн ТННЭ Ноос ноолуурын стандартын 1.0 хувилбарт зөвхөн ноолуурыг авч үзсэн. Гэхдээ ирээдүйд бусад мал (магадгүй тэмээ, сарлаг, адуу)-г хамруулж болохуйц байхаар редакцын өөрчлөлтүүд хийгдсэн.

## Өөрчлөлт хийх буюу хүчин төгөлдөр болох хугацаа

ТННЭ тохирлын гэрчилгээ эзэмшигчдийн хувьд “ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолуур үйлдвэрлэлдээ шинэчилсэн стандартыг нэвтрүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай. Өөрөөр хэлбэл, 2025 оны 4 сарын 1 хүртэл стандартын хуучин хувилбарын дагуу тохирлын гэрчилгээг олгож байж болно гэсэн үг юм. Тус өдрөөс өмнө олгосон гэрчилгээнүүд хугацаа нь дуусах хүртлээ хүчин төгөлдөр хэвээр байх ба хугацаа нь дууссаны дараа аж



ахуйн нэгж нь ТННЭ Ноос Ноолуурын Стандарт, хувилбар 1.0-ын дагуу гэрчилгээ авах хэрэгтэй болно. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

## ТННЭ Мөшгөлтийн тогтолцооны стандарттай уялдах байдал

ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандартад хяналт, шинэчлэлт хийгдсэн ба шинэ хувилбарыг 2024 оны 4 сарын 1-ны өдөр нийтэлсэн. Тус хяналт, шинэчлэлтийн нэг хэсэг болох нэмэлт, өөрчлөлтийн хураангуйг [эндээс](#) харна уу. Энд анхаарах чухал зүйл нь тус стандартад “ТННЭ-ээр Баталгаажсан” ноос ноолуурыг хянах, арилжаалахтай холбоотой ямар журам мөрдөгдөх ёстойг нарийн тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, ТННЭ Ноос Ноолуурын Стандартын дагуу гэрчилгээ авах хүсэлтэй аж ахуйн нэгжүүд (бас тэдгээрийн биет байршлууд) нь ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын дагуу гэрчилгээ авсан байх ёстой гэсэн үг юм. Энэ нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцож буй үйлдвэрлэгчдэд илүү нарийн шалгалт, хяналт тавигдах болохыг илтгэнэ. Хэлэлцүүлгийн үр дүнд үүнд ямар нэг шүүмж гараагүй.

*Дэлгэрэнгүй мэдээлэл авах линк: [SFA's Chain of Custody Guidance for Tracking Certified Cashmere Fibre Supply Chain \(sustainablefibre.org\)](https://www.sustainablefibre.org/)*

*ТННЭ Ноос Ноолуурын Стандарт, хувилбар 1.0-ийн “хүчин төгөлдөр болох хугацаа” хэсгээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.*

## ТННЭ Мөшгөлтийн тогтолцооны стандартад орсон нэмэлт, өөрчлөлтүүд

Ерөнхий мэдэгдэл дээр ТННЭ лого ашиглах тухай маш олон удаагийн санал, хүсэлтэд үндэслэн бид ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын 1.1 хувилбарыг боловсруулж 2024 оны 10 сарын 1-ны өдөр нийтэлсэн.

Үүнд орсон өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдийг онцгой тохиолдолд ерөнхий мэдэгдэл дээр ТННЭ лого ашиглах боломжтой болгосон. Онцгой тохиолдол гэдэгт “ТННЭ-ээр Баталгаажаагүй” хэрнээ “ТННЭ-ээр Баталгаажсан” гэх ташаа ойлголт төрүүлэх эрсдэл бүхий бүтээгдэхүүн байхгүй тохиолдлыг хэлнэ.

Тус стандартын олон хувилбарыг ТҮБ нэг дор нягталж, давхар ажил хийхээс зайлсхийх үүднээс 1.0 хувилбарыг бүхэлд нь засварласан ба одоо байгаа системийг өөрчилж, шинээр “ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт”-ын 3.1 хувилбарыг боловсруулж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх хугацааг 2025 оны 3 сарын 1-ны өдөр байхаар тогтоосон. Гэхдээ стандартын 2.0 хувилбарт заасан гол боловсруулагч аж ахуйн нэгжүүдийг 2024 оны 11 сарын 1-ний өдрөөс эхлэн “ТННЭ Цэвэр Ноос Ноолуур Боловсруулах Стандарт”-ын дагуу гэрчилгээ авсан байх ёстой шаардлага хүчин төгөлдөр хэвээр байх ба 2024 оны 11 сарын 1-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлнэ. Энэ нь үндсэндээ аж ахуйн нэгжүүдийг 2025 оны 3 сарын 1-ны өдөр хүртэл ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Удирдамжийн 3.1 хувилбарын дагуу гэрчилгээ авах ажлаа үргэлжлүүлж болно гэсэн үг юм. Аж ахуйн нэгжүүд нь мөшгөлтийн платформыг бэлэн болсон даруйд ашиглах боломжтой байх хэрэгтэй. Тус платформыг ашиглалтад оруулах хугацаа төлөвлөснөөс удаж байгаа бөгөөд энэ онд амжиж төлөвгүй байна.

Үүнээс гадна, худалдан авагч нь ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандарт (2.6.2.L)-ын дагуу гэрчилгээ авсан бол гүйлгээний бүртгэл дээр зөвхөн худалдан авагчийн тохирлын гэрчилгээний дугаарыг бичнэ гэж тодотгол оруулав. Мөн тухайн гүйлгээний бүртгэлд сонирхож буй ноос ноолуурд хамаарах ТННЭ эзлэхүүнээс хамаарах төлбөрийг төлсөн эсэхийг тэмдэглэх ёстой тухай оруулж өгөв.

*ТННЭ Мөшгөлтийн Тогтолцооны Стандартын 1.1 хувилбартай [энд](#) дарж танилцана уу.*



## ТННЭ Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлагад орсон өөрчлөлтүүд

Бид тус гарын авлагыг өнгөрсөн жил шинэчлэгдсэн ОУНБОМИШХ (ISEAL) Зохистой Дадлын Кодын шинэ шаардлагуудад нийцүүлэн шинэчлэв. Оруулсан өөрчлөлтүүдийг тухайлан мэдэхийг хүсвэл шинэчилсэн ТННЭ Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлагын нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлийг харна уу.

## Хэлэлцүүлгийн үр дүнд орсон бусад өөрчлөлтүүд

Бид хэлэлцүүлгийн явцад гарсан санал, үр дүнгүүдэд үндэслэн бусад олон өөрчлөлтийг оруулсан. Хүснэгт 1-д оруулсан өөрчлөлтүүдийг жагсаав.

### Хүснэгт 1: Хэлэлцүүлгийн үр дүнд орсон бусад өөрчлөлтүүд.

Бүлэг (Заалт)	Нэмэлт, өөрчлөлт
Аж ахуйн нэгжийн бүтэц (3.6)	Аж ахуйн нэгж нь удирдлагын төлөөлөгчийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг ТҮБ болон ТННЭ-д ажлын 10 хоногт багтаан мэдэгдэх байсныг ажлын 20 хоног болгож сунгав. <i>Үндэслэл: 10 өдөр байх нь хэт богино хугацаа гэж үзэв.</i>
Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ (6.1 e)	Стандартын шаардлагуудыг хангахын тулд аж ахуйн нэгж нь гүйцэтгэсэн ажлынхаа бүртгэлийг сар бүр шинэчлэх байсан бол одоо жилд багадаа нэг удаа шинэчлэх боломжтой болов. <i>Үндэслэл: Гарах нөлөө бага байтал хэт их ачаалал үзүүлж байна гэж үзэв.</i>
Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ (6.3)	Бүртгэл хөтлөлтийг хадгалж архивлах хугацаа 10 жил байсныг 5 жил болгож багасгав. <i>Үндэслэл: Гарах нөлөө бага байтал хэт их ачаалал үзүүлж байна гэж үзэв.</i>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10.7)	Ажилчид ажиллуулдаггүй буюу байршиж ажилладаг хүнгүй биет байршлууд галын дохиололтой байх шаардлагаас чөлөөлөгдөх заалтыг оруулж өгөв. <i>Үндэслэл: Тухайн нөхцөлд тохирохгүй шаардлагуудаас зайлсхийх.</i>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10.8)	Ажилчид ажиллуулдаггүй биет байршлууд галын гарц, бие засах өрөө байршуулах, эсвэл жирэмсэн/асрагч эмэгтэйчүүдэд зориулсан тохиромжтой орчин бий болгох шаардлагагүй гэсэн заалтыг хасаж, яагаад энэ бүхэн хэрэггүй гэдгийг зөвтгөх үндэслэлээ тайлбарлахыг шаардлага болгов. <i>Үндэслэл: Ажилчин байх эсэхээс үл хамааран бүх хүн энэ мэт дэд бүтцүүдийг ашиглах хэрэгцээтэй, эрхтэй. Зарим нөхцөл байдалд үл зохицох шаардлагуудыг таньж, тэдгээрээс чөлөөлөгдөх үндэслэл гаргах боломжтой болов. Жишээ нь алслагдмал газарт бие засах өрөө гаргах/барих нь нөхцөл байдалд үл зохицох шаардлага юм.</i>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10.8 b)	Хаалга байхгүй малын сараа зэрэг гарах гарц ойлгомжтой газруудад галын ослын үед зугтах гарц гаргана гэсэн шаардлагаас чөлөөлөв. <i>Үндэслэл: Тухайн нөхцөлд тохирохгүй шаардлагуудаас зайлсхийх.</i>

Бүлэг (Заалт)	Нэмэлт, өөрчлөлт
Хамгаалал ба нөхөн сэргээлт (12.1)	Ашиглаж буй газрынхаа байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хадгалах нь аж ахуйн нэгжийн үүрэг хариуцлага байхаас гадна мөн биет байршлуудынх нь хүлээх үүрэг хариуцлага байна. <i>Үндэслэл: Энэ нь аж ахуйн нэгжүүд биет байршлуудынхаа хүчин чармайлт гаргахад нь чухал үүрэг гүйцэтгэх болохыг илтгэнэ.</i>
Шим тэжээл ба ус (16.5)	Биет байршил нь малын эмчийн зааварчилгаагаар эсвэл зайлшгүй шалтгааны улмаас ямааг малын дайвар бүтээгдэхүүн болон загасны гурилаар хооллож болно. Гэхдээ ямааг өвчтэй малын дайвар бүтээгдэхүүнээр хооллохыг хориглох заалт хүчин төгөлдөр байна. <i>Үндэслэл: НҮБ-ийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас малчдыг онцгой тохиолдолд өвчтэй малыг эрүүл малын дайвар бүтээгдэхүүнээр хооллохыг зөвлөсөн<sup>1</sup>.</i>
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.2.2)	Өвчин халдварлах эрсдэлтэй тохиолдолд өвчтэй малыг сүргээс тусгаарлах шаардлагыг оруулсан. <i>Үндэслэл: Малын тавлаг байдлын мэргэжилтнүүдийн зөвлөмж.</i>
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.5)	Амьтдыг бүрэн тусгаарлахаас сэргийлэх зааварчилгаанд тусгаарлах ямааг бусад мал сүрэгтээ харагдахуйц, сонсогдохуйц байлгах гэдэг дээр нэмж “үнэрлэх” боломжтой байлгах заалтыг нэмсэн. <i>Үндэслэл: Ямааны хувьд үнэр чухал мэдрэхүй байдаг.</i>
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.5)	Шинээр сүрэгт нэмэгдэж буй малыг хөл хорионд байлгаж тусгаарлах хугацаа 30 хоног байсныг 21 хоног болгож багасгасан. <i>Үндэслэл: Үйлдвэрлэгчдийн санал. Гэхдээ өвдсөн байх боломжтой малыг хөл хорионд байлгах ёстойг анхаарах.</i>
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.5)	Шинээр сүрэгт нэмэгдэж буй малыг хөл хорионд байлгах нь сайжруулах үзүүлэлт бус нэг шалгуур болсон. <i>Үндэслэл: Ямааны тавлаг байдалд тустай гэж үзэв.</i>
Үржүүлэг (23.5)	Зохиомол хээлтүүлгийн үеэр ашиглах хориотой аргуудад төхөөрөмж ашиглан эр бэлгийн эс гарган авах (electro-ejaculation) аргыг нэмсэн. <i>Үндэслэл: Малын тавлаг байдлын мэргэжилтнүүдийн зөвлөмж.</i>

<sup>1</sup> [https://www.fao.org/fileadmin/user\\_upload/FAO-countries/Mongolia/docs/Malchdad\\_ogoh\\_zovlomj\\_book.pdf](https://www.fao.org/fileadmin/user_upload/FAO-countries/Mongolia/docs/Malchdad_ogoh_zovlomj_book.pdf)

Бүлэг (Заалт)	Нэмэлт, өөрчлөлт
Төл авах, бойжуулах (24.1)	<p>Зөвтгөх үндэслэлгүйгээр кесар хагалгаа хийхгүй байх шаардлагыг оруулсан.</p> <p><i>Үндэслэл: Кесар хагалгаа хийх үзэгдэл ховор ба мал дутуу төрөх нь тохиолдож болох үзэгдэл. Иймд кесар хагалгааг тогтсон норм болгохын оронд тодорхой шалтгаанд үндэслэдэг байх хэрэгтэй.</i></p>
Төл авах, бойжуулах (24.6)	<p>Төлд өгөх уургыг бэлтгэх нь сайжруулах үзүүлэлт байсныг шаардлага болгож өөрчилсөн.</p> <p><i>Үндэслэл: Энэ төрлийн бүтээгдэхүүнүүд дуусах хугацаа урт, нунтаг хэлбэрээр байдаг тул үйлдвэрлэгчдийн хувьд бодож байснаас нь амар байх болно гэж үзсэн.</i></p>
Төл авах, бойжуулах (24.9)	<p>Төл малыг сүүнээс гаргах насыг 8 долоо хоног байсныг 16 долоо хоног болгож уртасгасан.</p> <p><i>Үндэслэл: Малын тавлаг байдлын мэргэжилтнүүдийн зөвлөмж.</i></p>
Ажил, уналга, эдэлгээний мал (25.9)	<p>“Ажил, уналга, эдэлгээний мал амьтад нь ноос ноолуурын малыг гэмтээхээргүй байх” гэсэн сайжруулах үзүүлэлтийг гаргасан.</p> <p><i>Үндэслэл: Энэ нь анзаараагүй орхисон алдаа байсан.</i></p>



## Хэлэлцүүлгийн үр дүнд хийгдсэн бусад тодруулгууд

Хэлэлцүүлгийн үеэр ямар зорилго, агуулгатай болох нь тодорхойгүй заалтууд ажиглагдсан бөгөөд тэдгээрт тодруулга хийх хэрэгтэй болсон. Хүснэгт 2-т оруулсан тодруулгуудыг нэгтгэв.

### Хүснэгт 2: Хэлэлцүүлгийн үр дүнд хийгдсэн нэмэлт тодруулгууд.

Бүлэг (Заалт)	Тодруулга
Аюул (5.2)	Зарим бүтээгдэхүүнд аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас байхгүй байх боломжтой тул “аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудастай байх” гэсэн шаардлагыг “аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудас зэргийг багтаасан үйлдвэрлэгчийн заавар” гэсэн шаардлагаар орлуулав.
Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ (6.2)	Засгийн газар эсвэл орон нутгийн малын эмч зэрэг бусад байгууллага, хувь хүний цуглуулсан бүртгэлд хандах эрхтэй, ТҮБ-д хуваалцах боломжтой тохиолдолд аж ахуйн нэгж нь давхар бүртгэл хөтлөх шаардлагагүй.
Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ (6.1 h; 6.1 i)	Худалдаа, төлбөртэй холбоотой бүртгэл хөтлөх шаардлагууд нь ноолуурын худалдаа, төлбөрийг заана.
Аж ахуйн нэгжийн бүртгэл хөтлөлт, үнэлгээ (6.3)	Аж ахуйн нэгж нь анх гэрчилгээ авсанаас хойших дор хаяж 10 жилийн хугацааны бүртгэлийг хадгална (аж ахуйн нэгжүүд гэрчилгээ авахаас урьдаж 10 жилийн бүртгэлийг үзүүлэх шаардлагагүй).
Тогтмол сайжруулалт (7.4.5)	“Уламжлалт мэдлэг” гэж тухайн газар нутагт амьдарч буй нутгийн иргэд, ноолуурын үйлдвэрлэлд гар бие оролцож буй орон нутгийн ажилчид эсвэл ноолуурын үйлдвэрлэлтэй ойр ажилладаг иргэний нийгэмлэгийн эзэмшсэн мэдлэгийг хэлнэ.
Тогтмол сайжруулалт (7.5)	Цаг агаарын өөрчлөлтийн улмаас хувьсан өөрчлөгдөж буй цаг агаарын төлөв байдалтай уялдуулан мал аж ахуй эрхлэх гэсэн сайжруулах үзүүлэлт нь үндсэндээ малын тоо толгойг зохистой хэмжээнд байлгаж, бие бялдрын хувьд чийрэг, шилмэл сүрэг үржүүлэх тухай бөгөөд энэ нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд амьтдыг дасан зохицоход нь туслах юм.
Хариуцлагатай газар эзэмших эрх (8.4)	Аж ахуйн нэгжүүд нь тэдэнд олгосон эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх гэсэн шаардлагад “ТННЭ-ээр Баталгаажсан” бүтээгдэхүүнээс олсон нэмэлт ашгийг хуваах заалт мөн багтана.

Бүлэг (Заалт)	Тодруулга
Хөдөлмөр эрхлэлт (9.1)	ОУХБ-ын 29-р конвенц гэдгээр ОУХБ-аас тодорхойлсон албадан хөдөлмөр эрхлэлтийг илтгэх үзүүлэлтүүдийг хэлэв. Хөдөлмөрийн гэрээний нөхцөлөөс гаднах аливаа ажлыг нэмэлт буюу/эсвэл илүү цагаар ажилласан ажилд тооцох бөгөөд тухайн нөхцөлд ажилтан нэмэлт цалин урамшуулал авах ёстой.
Хөдөлмөр эрхлэлт (9.4)	Гэрээнд урамшуулалт цалин хөлстэй холбоотой нөхцөлүүд байх ёстой. Гэрээнд малд гарз гарсан аливаа тохиолдолд ямар үед ажилтан санхүүгийн хувьд хариуцлага хүлээх ёстойг, мөн үүнийг хэрхэн шийдэх талаар тодорхой тайлбарласан байх.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10.9)	Заалт 10.9 нь ажилчдын хоол унд идэх, хоол хүнсээ хадгалахтай холбоотой заалт юм. Мал амьтдын тухайд заалт 16.2-ыг харна уу.
Хамгаалалт ба нөхөн сэргээлт (12.3)	Тунадасжих процессыг бага түвшинд байлгахтай холбоотой шаардлагууд нь биет байршлын тунадасжилтыг хянахад авах арга хэмжээтэй холбоотой. Энэ нь биет байршлуудад усны эх үүсвэрийг тунадасгүй, цэвэр байлгах үүрэг хариуцлага оноосон асуудал биш юм.
Мал маллагаа ба зохистой харьцаа (14.3)	Ямааг уях эсвэл сагсанд хийсэн тохиолдолд тээвэрлэлт хийхийг зөвшөөрөх тухай удирдамжийг хассан. Учир нь энэ нь зарим оронд хууль бус гэж тооцогддог.
Ноос ноолуур авах (15.5)	Ноос ноолуур авахаас өмнө дөрвөн цагийн турш ямаанд өвс тэжээл, ус өгөхийг хязгаарлах ёстой.
Шим тэжээл ба ус (16.14)	‘аажмаар’ гэдэг нь ямаанд идэш тэжээлд нь орох өөрчлөлтөд дасах хангалттай хугацаа буюу хамгийн багадаа хоёр долоо хоногийн хугацаа өгөх ёстойг илтгэнэ.
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.1)	Малын эмч жил бүр биет байршилд очих ёстой гэсэн сайжруулах үзүүлэлт.
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.2.1)	Ажиглалтад байгаа өвчтэй малыг 24 цагийн хугацаанд наанадаж хоёр удаа эргэж тойрох ёстой.
Эмнэлгийн тусламж ба ажиглалт (17.7)	Зөвхөн үндэслэл бүхий шалтгаанаар малыг хөнгөлөх тухай заалтын найруулгыг сайжруулахын тулд тус текстийг “зөвтгөх үндэслэлгүйгээр малыг хөнгөлөх ёсгүй” болгож өөрчилсөн.

Бүлэг (Заалт)	Тодруулга
Байр болон хашаа (19.11)	Хаалттай орон зай гэдэг нь чөлөөтэй хөдлөх боломж нь хязгаарлагдмал аливаа оройн зайг хэлэх ба үүнд байр, хашаалсан газар, тээвэрлэлтийн машин зэрэг орон бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Түүнчлэн ТННЭ Нэр Томьёоны Толь бичигт оруулсан.
Байр болон хашаа (19.11)	Малын байр сууцанд шал хийсэн тохиолдолд дээр нь дэвсгэр байрлуулсан байх ёстой.
Байр болон хашаа (19.8)	‘сайн агаар сэлгэлттэй’ гэдэг нь таагүй эсвэл хурц үнэргүй байх ёстойг илтгэнэ. Аммиак буюу шүвтрийн түвшнийг 1-2 ppm-ээс доош байлгаж, цаг тутамд 10-20 удаа агаар сэлгэж байх шаардлагатай.
Тээвэрлэлт (21.5)	Тээвэрлэлтээс өмнө мал амьтдад өгөх тэжээл, ус нь шим тэжээлтэй, шууд өгөх боломжтой байх ёстой.
Тээвэрлэлт (21.6)	Тээвэрлэлт хооронд амрах хугацаа 8 цаг байх ёстой ба ямаанд хангалттай зай талбай гаргаж хөдөлгөөн хийх боломжоор хангана. Нэг ямааны хувьд оногдох зай талбай 5м.кв байна.
Үржүүлэг (23.1)	Мал үржүүлэх стратеги нь малын амархан төрөх чадамж, өвчлөлд өртөмтгий биш байх чадвар зэргийг бодолцсон байх ёстой.
Үржүүлэг (26.1)	‘Ноос ноолуурын чанар’ гэсэн нь урт, ширхэглэг, өнгийг илтгэнэ.
Олон бүлэг, заалт	‘жил бүр шинэчлэгдэх’ гэдэг нь ‘жилдээ наанадаж нэг удаа шинэчлэгдэх’ гэсэн утгыг илтгэнэ.
Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлага (24.6.1.k)	Санамсаргүй эерэг ба сөрөг (зүгээр ч нэг сөрөг биш) нөлөөнүүдийг аж ахуйн нэгж тэмдэглэсэн байх ёстой.
ТННЭ Нэр томьёоны тайлбар толь	Мэргэшсэн хүмүүс гэдэг нь ТҮБ-д өөрсдийн мэргэшил, ур чадвараа харуулах, бататгах чадамжтай хүмүүсийг хэлнэ.

## Юу өөрчлөгдөөгүй вэ?

ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарын хамрах хүрээ глобал хэмжээнд зорьсон хэвээр байх ба үр дүнтэй менежмент, зохистой ажил хөдөлмөр, биологийн олон янз байдал, малын тавлаг байдал болон ноос ноолуурын чанарын сайжруулалт дээр төвлөрөх ажлаа үргэлжлүүлнэ.

# Хавсралт 1: Оролцогч талуудын оролцоо

## Арга аргачлал

Ноолуурын стандартад хийгдэх хяналт, үнэлгээний ажлын нэг хэсэг болгож ТННЭ-ийн зүгээс оролцогч талуудад стандарттай холбоотой санал, хүсэлтээ илэрхийлэх хангалттай цаг хугацаа, боломжийг олгосон билээ. Тухайлбал 2024 оны 5 сарын 29-өөс 2024 оны 8 сарын 5-ны өдөр хүртэл нийт 60 өдрийн хугацаанд нээлттэй байх цахим судалгааг бид веб сайтаараа дамжуулан явуулсан. Энэ хугацаанд тус хэлэлцүүлгийн талаарх зар, мэдээг веб сайт, гишүүдэд хандсан албан ёсны мэдэгдэл, сар бүрийн сонин мэдээ, мэйл зэргээр дамжуулж түгээсэн байна. Хэлэлцүүлэгтэй холбоотойгоор дараах агуулгатай мэйлүүдийг илгээсэн: үүнд, а) хэлэлцүүлэг албан ёсоор нээгдсэн тухай, б) оролцогч талуудад хэлэлцүүлэг дундаа орсныг мэдэгдэж идэвх оролцоотой оролцохыг сануулах, в) оролцогч талуудад хэлэлцүүлэг дуусахаас нэг долоо хоногийн өмнө хэлэлцүүлэгтээ идэвх оролцоотой оролцохыг дахин сануулах, г) хэлэлцүүлэг дуусах хугацаа анх зарлагдсан хугацаа (2024 оны 7 сарын 29)-с долоо хоногоор сунгагдсан болохыг мэдэгдэх. Түүнчлэн бид зарим ТННЭ гишүүдтэй тусдаа ярилцлага хийсэн бөгөөд бусад оролцогч талууд мэйлээр дамжуулан санал, зөвлөгөө ирүүлсэн. Ноолуур үйлдвэрлэлийн нийгэмлэг, бүлгэмүүдтэй харилцаа холбоотой байх үүднээс Монгол болон Хятад улсуудад тухайн улсынх нь хэл дээр тодорхой үйл ажиллагаанууд зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаанд оролцогсод нийт хэлэлцүүлэгт оролцогсдын дийлэнх хувийг бүрдүүлсэн. Тухайлбал Монгол улсад зохиогдсон үйл ажиллагаанд 42, Хятад улсад зохиогдсон үйл ажиллагаанд 35 оролцогч тус тус хамрагдсан байна.

Үүнээс гадна ТННЭ нь [Нээлттэй Хэлэлцүүлгийн Портал](#)-ыг ажиллуулдаг ба үүнийг ашиглан оролцогч талууд хүссэн үедээ ТННЭ-ийн зүгээс хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдтэй холбоотой санал сэтгэгдлээ илэрхийлэх боломжтой байдаг. ТННЭ Ноолуурын Стандарттай холбоотой хоёр санал сэтгэгдэл тус порталаар дамжин ирсэн ба тэдгээрийг илгээсэн талуудыг ТННЭ Ноолуурын Стандартын олон нийтийн хэлэлцүүлэгт нэгдэх чиглэлийг өгсөн. Энэхүү портал нь үргэлж нээлттэй хэвээр байх болно.

Цаашилбал, энэхүү баримт бичгийг хөгжүүлэх ажлын нэг хэсэг болгож, мөн ТННЭ Ноос Ноолуурын Стандартыг ноороглох, эцсийн хувилбарыг гаргахад бид хэд хэдэн оролцогч талуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ТННЭ Стандарт Тохируулгыг Сайжруулах Комисс (СТСК)-той холбоотой ажилласан. СТСК-ийн гишүүн болох хүсэлтэй бол [standards@sustainablefibre.org](mailto:standards@sustainablefibre.org) хаяг руу мэйл бичнэ үү.

## Идэвхи оролцоо

Энэ хэсэгт хэлэлцүүлэгт оролцогчдын мэдээллийг танилцуулав. Зарим оролцогч нэгээс илүү үйл ажиллагаанд оролцсон байна.

### Хүснэгт 3: Оролцогчид /санал ирүүлэгчдийн тоо.

Оролцогч тал	Нийтийн хэлэлцүүлэг	Ярилцлага /мэйл	Семинар/ бусад	Нийт
Академик судалгаа, шинжилгээний байгууллага	2	2	7	11
Ноолуурын ферм/мал аж ахуй			45	45
Ноолуурын анхдагч боловсруулалт	1		4	5
Ноолуурын хоёрдогч боловсруулалт, үйлдвэрлэл	3			3
Ноолуурын худалдаа, брэндүүд, жижиглэн худалдаа	2	3		5
Удирдлага буюу менежмент				0
Төрийн бус байгууллага	1	3		4
Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ, магадлан итгэмжлэл	2	1	11	14
Мэдээлэл тодорхойгүй			22	22
<b>Нийт</b>	<b>11</b>	<b>9</b>	<b>89</b>	<b>109</b>

### Хүснэгт 4: Оролцогчид/санал ирүүлэгчдийн тоо, газарзүйн байршлаар.

Газарзүйн байршил, бүс	Нийт
Ази	97
Европ	8
Хойд Америк	1
Номхон Далайн Арлууд	3
<b>Нийт</b>	<b>109</b>

## Бусад

Энэ хэсэгт бид хэлэлцүүлгийн үеэр дэвшигдсэн боловч дээрх хэсэгт дурдагдаагүй, Стандартад нэмэлт, өөрчлөлт байдлаар ороогүй зарим асуудлын хураангуйг танилцуулав. Оруулаагүй учир шалтгааныг тайлбарлаж, зарим асуудлуудын тухайд хэрэгжүүлбэл зохих дараачийн алхмуудыг дурдав. Тэдгээр нь гурван ангилалд хуваагдана: (1) ТННЭ-ийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдэд цаашдаа анхаарвал зохих хяналт, үнэлгээтэй холбоотой дэвшигдсэн асуудлууд, (2) стандартад өөрчлөлт оруулахтай холбоогүй асуудлууд, (3) өөрчлөлт оруулах шаардлагагүй асуудлууд. Оролцогч талуудын өгсөн бодит санал сэтгэгдлийг (нэрийн нууцлалтай) үзэхийг хүсвэл [standards@sustainablefibre.org](mailto:standards@sustainablefibre.org) хаягт хүсэлт гаргаснаар авах боломжтой.

### Цаашид анхаарвал зохих асуудлууд

Хүснэгт 5-д цаашид анхаарвал зохих асуудлуудыг харуулав. Энд сайтар хөгжүүлэх боломжгүй, хэрэгжилтийн өмнөх нөлөөллийн шинжилгээг хийхэд нэгэнт оройтсон гэхдээ анхаарвал зохих асуудлуудыг багтаасан. ТННЭ Ноолуурын Стандартын 1.0 хувилбарыг танилцуулах хугацааг хойшлуулсан тохиолдол байдаг. Иймд тодорхойгүй, шийдэгдээгүй асуудлуудыг шийдэх гэж хугацаа алдалгүйгээр хангалттай хэмжээнд сайжруулсан ТННЭ Ноос Ноолуурын Стандартын 1.0 хувилбарыг олон нийтэд даруй танилцуулах нь илүү чухал гэж үзэв.

### Стандартад өөрчлөлт оруулахтай холбоогүй асуудлууд

Хүснэгт 6-д энэ ангилалд оруулсан асуудлуудыг харуулав.

### Өөрчлөлт оруулахад хүргээгүй асуудлууд

Хүснэгт 7-д энэ ангилалд орсон асуудлуудыг харуулав. Яагаад өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн тухай тайлбарыг мөн тусгасан.

Хүснэгт 5: Сайтар хөгжүүлэх, хэрэгжилтийн өмнөх нөлөөллийн шинжилгээ хийхэд нэгэнт оройтсон гэхдээ анхаарвал зохих асуудлууд. В = асуудалтай, хэрэгжүүлэхээс өмнө нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай; F = биелүүлэхэд хүндрэлтэй; O = стандартын хамрах хүрээнд орохгүй, өөр стандартад хамаарах; R = заалтуудыг тодорхой болгоход илүү суурин судалгаа шаардлагатай, хэдийгээр бэлэн судалгаа байж болох боловч ТННЭ-ийн зүгээс хянах, үнэлэх хэрэгтэй.

Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
Үр дүнтэй удирдлага	Сургалтад хамрагдах тухай сайжруулах үзүүлэлтүүдийг шаардлага болгох хэрэгтэй.	В	Төрийн бус байгууллага
	Бүртгэл хөтлөлтийн сайжруулах үзүүлэлтүүдийг шаардлага болгох хэрэгтэй.	В; F <sup>2</sup>	Төрийн бус байгууллага
Зохистой хөдөлмөр эрхлэлт	Амралтын өдрүүдэд олгох цалин хөлс болон цалин хөлс олгох тогтолцоотой холбоотой заалтуудыг оруулах.	В	Ноолуурын худалдаа эрхлэгчид, брендүүд, жижиглэнгийн худалдаачид
	Аж ахуйн нэгжүүд нь хүйсийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг болон бусад хүйсийн эрх тэгш байдлыг хангах санаачилгуудыг дэмжинэ гэсэн сайжруулах үзүүлэлтийг оруулах.	В	Академик судалгаа, шинжилгээний байгууллага
	Аж ахуйн нэгжүүд нь эмэгтэй малчдыг болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийг үйл ажиллагаандаа хамруулж, гишүүнээр элсүүлэх, удирдах албан тушаалд ажиллуулж, бүх түвшинд үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг хөхүүлэн дэмжих, урамшуулахыг зорих.	В	Академик судалгаа, шинжилгээний байгууллага
	Жижиг аж ахуйн нэгжүүдийн хүчин чармайлтаас хэтэрсэн асуудал байж болох хэдий ч аж ахуйн нэгжүүдийг гомдол, зарга хүлээн авах, шийдвэрлэх тогтолцоо хэрэгжүүлэхийг шаардах.	В	Академик судалгаа, шинжилгээний байгууллага

<sup>2</sup> Бичиг үсэг тайлагдсан эсэхээс шалтгаалан хэрэгжихгүй байх боломжтой.



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
	Албадан хөдөлмөр эрхлэлт, хүүхдийг хөдөлмөр эрхлэлтээс гадна өр зээлээс хараат байдал, бэлгийн мөлжлөг, хууль бус наймаа зэрэг өргөн хүрээг хамарсан орчин үеийн боолчлол, хүнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудаас хамгаалах.	B	Ноолуурын худалдаа эрхлэгчид, брэндүүд, жижиглэнгийн худалдаачид
Биологийн олон янз байдал ба газар ашиглалт	Стандарт нь аюултай хог хаягдлаас гадна бүх хог хаягдлын устгалыг хамруулах.	B	Ноолуурын ферм/мал аж ахуй
	Стандарт нь зэрлэг байгальд амьдардаг амьтад, тэр дундаа ямааг идшээ болгодог махчин амьтад зориудаар заналхийлэх үйл ажиллагаануудыг хориглох.	B	Төрийн бус байгууллага
	Аюултай бодисоор бохирдсон газрын нөхөн сэргээлттэй холбоотой сайжруулах үзүүлэлтүүдийг шаардлага болгох.	B	Ноолуурын хоёрдогч боловсруулалт, үйлдвэрлэл
Малын тавлаг байдал	Стандартад байнга авч хэрэгжүүлэх нийтлэг мал маллагааны дадлуудад ямааг аажмаар дасгах тухай заалтуудыг оруулах.	B	Төрийн бус байгууллага
	Эм ямаанд оногдох ухнын тоо ухнын настай холбоотой байх ёстой гэсэн шаардлагад тодруулга хэрэгтэй.	R	Ноолуурын ферм/мал аж ахуй; Төрийн бус байгууллага; Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ/магадлан итгэмжлэл





Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
Малын тавлаг байдал	Малын эмч мал сүрэгт жил бүр үзлэг шалгалт хийсэн байх гэсэн сайжруулах үзүүлэлтүүдийг шаардлага болгох.	B	Төрийн бус байгууллага
	Малыг хүйтэнд байлгах, тамгалах, болон бусад арга ашиглан тэмдэг тавих, тамгалахыг хориглох.	B	Төрийн бус байгууллага
	Өвчтэй, доголлон, шархтай ямааг эмчлэх шаардлагыг илүү тодорхой болгох буюу тус шаардлагад яг ямар эмчилгээ авах ёстойг тусгах.	R	Төрийн бус байгууллага
	Малын туурайг шалгах шаардлагыг малын биеийг бүхэлд нь шалгах болгож сайжруулах.	B; R	Төрийн бус байгууллага
	Шимэгчдээс сэргийлэх шаардлагыг малын эрүүл мэндийг хамгаалах, сэргийлэхэд шаардлагатай бүх асуудлуудыг хамруулах болгож сайжруулах.	B; R	Төрийн бус байгууллага
	Биет байршил нь малд үзүүлсэн эмчилгээний бүртгэл хөтөлнө гэсэн сайжруулах үзүүлэлтийг шаардлага болгох.	B; F <sup>3</sup>	Төрийн бус байгууллага
	Аж ахуйн нэгж нь биет байршлуудад нь мал өвчинд хэр өртөмтгий байгааг үнэлэх, асуудал ажиглагдсан тохиолдолд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэсэн шаардлагыг стандартад оруулах.	B	Төрийн бус байгууллага

<sup>3</sup> Бичиг үсэг тайлагдсан эсэхээс шалтгаалан хэрэгжихгүй байх боломжтой.



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
Малын тавлаг байдал	Өвчин намдаах, мал хөнгөлөхтэй холбоотой сайжруулах үзүүлэлтүүдийг шаардлага болгох.	B; R <sup>4</sup> ; F <sup>5</sup>	Ноолуурын худалдаа эрхлэгчид, брэндүүд, жижиглэнгийн худалдаачид; Төрийн бус байгууллага
	Бэлчээр ашиглалттай холбоотой заалтуудад бэлчээр ашиглах хамгийн бага хугацааг тогтоож өгөх.	R	Төрийн бус байгууллага
	Малын тавлаг байдлын төлөвлөгөөнд тавигдах шаардлагууд нь зөвхөн хашаанд ихэнх цагийг өнгөрөөсөн ямааг хамруулах бус бүх ямааг хамруулах хэрэгтэй.	B	Төрийн бус байгууллага
	Хашаа, байранд байх ямааны хувьд ямаа бүрд оногдох талбай 2 м.кв, гэхдээ эвэртэй ямааны хувьд 2.5 м.кв байна гэсэн шаардлага тавих.	B	Төрийн бус байгууллага
	Хаалттай орчныг тодорхойлсон шаардлагууд илүү тодорхой байх хэрэгтэй ба “агааржуулалт сайн байх” гэдгээс илүү шаардлагуудыг тавих хэрэгтэй. Тухайлбал, температур, чийгшил, агаарын чанар (үүнд зохимжтой хэмжээг тусгасан байх) гэх мэт.	B; R	Төрийн бус байгууллага
	Хаалттай орчинд тавигдах шаардлагууд хангагдаагүй тохиолдолд дохиолол ажиллах, сэрэмжлүүлэг өгөх тухай шаардлагыг оруулж өгөх.	B	Төрийн бус байгууллага
	Байгалийн бус гэрэл нь эргэн тойрныг бүрэн гэрэлтүүлж, анивчихгүй, зохих хэмжээний тод, дээд болон доод хэмжээг нь тодорхой тусгасан шаардлагыг оруулах.	B; R	Төрийн бус байгууллага

<sup>4</sup> Уураг шахах аргаар хөнгөлөх (immuno-castration) аргыг санал болгодог, ач тустай боловч заах зээлд худалдааны зориулалтаар хараахан гараагүй байна.

<sup>5</sup> Эм, тариа авах боломж хомсоос гадна хөнгөлсөн малын бүтээгдэхүүн хүмүүсийн хүнсний хэрэглээнд очих тул эмийн нөлөөллийн үүднээс боломжгүй.



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
Малын тавлаг байдал	Завсартай шалыг хориглох, эсвэл шалны болон завсар хоорондын зузааны байж болох бага хэмжээг тусгах. Тухайлбал, шалны зузаан багадаа 36мм, завсар хоорондын зай багадаа 12мм байх.	B	Төрийн бус байгууллага
	Малын хашаа хороог тогтмол цэвэрлэхийг шаардах. Ингэхдээ цэвэрлэгээг ямар давтамжтайгаар, ямар хэмжээнд байлгах ёстой зааврыг нарийн тусгах.	B	Төрийн бус байгууллага
	Шинээр төрсөн төл болон эх малд нэмэлт саравч гаргахыг шаардах хэрэгтэй. Одоо байгаа стандарт нь төллөх дөхсөн малд саравч гаргахыг шаарддаг.	B	Төрийн бус байгууллага
	Хөхнөөс гарж амжаагүй төлийг тээвэрлэхийг хориглох хэрэгтэй.	B	Төрийн бус байгууллага
	Хээлтэй, хөхүүл төл, өвчтэй/өвдсөн болон бусад эмзэгшсэн малыг хэзээ, хэрхэн зөөх, хөдөлгөж болох тал дээр хязгаар тавих.	B; R	Төрийн бус байгууллага
	Эм малын үржил хоорондын хамгийн богино хугацааг 10 сар байсныг 12 сар болгох.	B	Төрийн бус байгууллага
	Нэг ухнад оногдох эм ямааны харьцааг 20:1-ээс бага байлгах.	B	Төрийн бус байгууллага
	Үржилд ороход асуудалгүй гэдгийг бататгах үүднээс мал сүрэгт (ялангуяа эцэг малд) тогтмол үржлийн шалгалт хийж байхыг шаардах.	B	Төрийн бус байгууллага
	Хүний оролцоотой мал төллүүлэх процессын улмаас тухайн төлд төрхийн эрсдэл дамжихаас сэргийлж кесар хагалгаа хийхийг хориглох.	B	Төрийн бус байгууллага
	Ажил, уналга, эдэлгээний малд зориулж зөөлөн, уян хатан чанартай дэвсгэр бэлдэхийг шаардах.	B	Төрийн бус байгууллага



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
Малын тавлаг байдал	Зөвхөн ажил, уналга, эдэлгээний малд зориулж анхны тусламжийн хайрцаг бэлдэх бус мөн ямаанд зориулж бэлдсэн байхыг шаардах.	B	Төрийн бус байгууллага
	Биологийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдтэй холбоотой илүү олон шаардлагуудыг оруулж өгөх.	B; R	Төрийн бус байгууллага
	Нядалгааны газрын тохиролцоонд зөвхөн нядалгаатай холбоотой шаардлагууд оруулахаас гадна тээвэрлэлттэй холбоотой шаардлагуудыг мөн оруулах.	B	Ноолуурын худалдаа эрхлэгчид, брэндүүд, жижиглэнгийн худалдаачид
	Самнах, хяргах үйл ажиллагааг зөвшөөрсөн нөхцөлүүдэд тодруулга хэрэгтэй.	B; R	Ноолуурын хоёрдогч боловсруулалт, үйлдвэрлэл
	Ямааг ижил сүрэгт нь байлгаж сүргийн нэг хэсэг болох, бусад сүргийн гишүүдэд нөлөөлөх боломжоор хангах гэсэн шаардлагыг хасах.	B; R	Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ /магадлан итгэмжлэл
	Малын үржилд хөндлөнгийн оролцоо байх нь ховор, малын биеийн байдал, онцлогоос шалтгаалж төл алдах тохиолдол байдаг тул “аж ахуйн нэгж нь үржилд нөлөөлөх хүний хөндлөнгийн оролцоог хянах, үнэлэх” гэсэн сайжруулах үзүүлэлтийг хасах. Энэ үзүүлэлтийг хэвээр хадгалж үлдэх нь тогтмол сайжруулалтын бусад нөлөө бүхий үзүүлэлтүүдийг анзаарахгүйд хүргэх боломжтой юм.	B; R	Ноолуурын ферм/мал аж ахуй; Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ/магадлан итгэмжлэл



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
<b>Малын тавлаг байдал</b>	Ямааны хоол хүнсний ихэнх хэсгийг нэмэлт тэжээл бүрдүүлдэг бол биет байршил нь нэмэлт тэжээлийн нийлүүлэлт тасалдсан үед авч хэрэгжүүлэх хоол тэжээлийн менежментийн төлөвлөгөөтэй байх. Тодруулбал, нэмэлт тэжээлийн тасалдалд эрс тэс цаг агаарын төлөв байдал, цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй хүндрэл зэрэг хамаарч болно. Тус төлөвлөгөө нь мал сүргийн тоо толгойг зохистой хэмжээнд байлгахад туслах бөгөөд хэцүү нөхцөл байдалд мал хорогдох/мал заазлахаас сэргийлэх боломжийг бүрдүүлнэ гэдгийг тусгах.	B	Төрийн бус байгууллага
	‘Ур чадвартай/туршлагатай’, ‘цэвэр’, ‘тохиромжтой’, ‘түргэн’, ‘үр дүнтэй’ гэсэн томъёоллуудад нарийн тодорхойлолт хэрэгтэй.	R	Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ/магадлан итгэмжлэл
	Ямааг зөнд нь үлдээхэд голдуу хоёроос илүү хугацаанд амардаг. Өдөрт үд дундын үед ямааны амрах хугацаа 2 цаг байсныг 2.5 цаг болгож уртасгах.	B	Стандарт тохируулга, нийцлийн үнэлгээ/магадлан итгэмжлэл
	Ноос ноолуурын мал нь мал хөнгөлөх үйл ажиллагааг сонсох, үнэрлэх, ямар нэг нөлөөлөл мэдрэхгүй байх хэрэгтэй.	B	Төрийн бус байгууллага
<b>Бусад</b>	Хугацаа заасан заалтуудад илүү нарийн цагийн хязгаар тавьж өгөх.	R	Төрийн бус байгууллага



Зарчим	Дараа удаа анхаарвал зохих асуудлууд	Хойшлуулах болсон шалтгаан	Асуудал дэвшүүлсэн
	Битүү өрөөнд хэт ягаан туяаны гэрэлд сууж ноолуур ялгадаг ажилчдыг хамгаалах заалт оруулах.	O <sup>6</sup>	Ноолуурын худалдаа эрхлэгчид, брэндүүд, жижиглэнгийн худалдаачид

<sup>6</sup> ТННЭ Цэвэр Ноос Ноолуурын Стандартад тусгагдсан



Хүснэгт 6: Стандартад өөрчлөлт оруулахтай холбоогүй санал сэтгэгдлүүд. Бидэнд ирүүлсэн санал сэтгэгдлийг, тэдгээрийн шийдлийн хамт оруулав.

Зарчим	Ирүүлсэн санал сэтгэгдэл ба тэдгээрт өгөх хариу, шийдэл
<p><b>Малын тавлаг байдал</b></p>	<p>“ТННЭ-ээр Баталгаажсан” үйл ажиллагаа явуулдаг газраас ямааг хараа хяналтгүй, гэрчилгээжээгүй нядалгааны газарт өгч байгаатай холбогдуулж зарим оролцогч талууд асуудал дэвшүүлсэн. Мал нядалгааны газруудыг гэрчилгээжүүлэх нь ТННЭ-ийн үйлчлэх цар хүрээнээс давсан асуудал боловч “ТННЭ-ээр Баталгаажсан” ноолуур үйлдвэрлэлд оролцож буй бүх ямааны тавлаг байдал, эрүүл мэндэд үргэлж анхаарсан хэвээр байх үүрэг хариуцлагатай болохыг ойлгож байна. Гэрчилгээтэй аж ахуйн нэгжүүдийн хамтарч буй мал нядалгааны газруудад нөлөө үзүүлж, хяналттай байлгах үүднээс бид гэрчилгээтэй аж ахуйн нэгжүүдийг мал нядалгааны газруудтай хууль ёсоор хүчинтэй гэрээ байгуулсан байх шаардлагыг хэрэгжүүлэх талаар бодолцов. Тус гэрээнд мал нядалгааны газар нь ТННЭ-ийн боловсруулсан малын тавлаг байдлын стандартуудын агуулга, шаардлагуудыг ойлгож, дагаж мөрдөх тухай тусгасан байна. Түүнчлэн тухайн гэрчилгээтэй аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах ажиглагч буюу Тохирлын Үнэлгээний Байгууллага (ТҮБ) нь тус гэрээг мөн үзэх эрхтэй байна.</p> <p>Хэлэлцүүлгийн явцад бид энэ ажлыг Хятад улсад хэрэгжүүлэх нь ихээхэн хүнд суртал дагуулах, цаг хугацаа авах боломжтойг тогтоосон. Учир нь Хятадад мал нядалгааны газруудыг төр ажиллуулах нь түгээмэл байдаг тул ямар нэг гэрээ тохиролцоо хийх бол гарын үсэг зурахаас өмнө гэрээг маш нухацтай авч үзэх нь гарцаагүй юм. Иймд бидний зүгээс аж ахуйн нэгжүүдэд сая дурдсан шинэ шаардлагыг хүлээн авч хэрэгжүүлж эхлэх хүртэл 12 сарын хугацаа өгөх шийдлийг гаргав. Стандартын 1.2 заалтад тусгагдсаны дагуу энэхүү шинэ шаардлагыг Хятад улсад хэрэгжүүлэх боломжгүй ч байж болно. Иймд шинэчилсэн стандартын тусламжтай малын тавлаг байдлыг үргэлжлүүлэн сайжруулахын тулд энэ асуудлыг хяналтад байлгаж, дараа дараачийн үнэлгээнд хамруулах хэрэгтэй.</p> <p>Эцсийн үр дүнд ТННЭ Стандарт Тохируулгыг Сайжруулах Коммис энэ шаардлагыг хэрэгжүүлэх боломжгүй (гүйцэтгэхэд хэцүү), хэрэгжүүлсэн тохиолдолд үр дүнтэй байх боломж бага, хянахад хүндрэлтэй байх болно гэсэн шүүмжлэлтэй байр сууринаас хандсан. Түүнчлэн энэ нь махны гэрчилгээжүүлэлттэй холбоотой асуудал тул бидний зорилттой нийцэхгүй байна. ТННЭ энэ асуудалд шийдэл олоход мах үйлдвэрлэл, мах үйлдвэрлэлийн гэрчилгээжүүлэлттэй ойр ажилладаг Бэлчээрийн Менежментийн Зөвлөлийг оролцохыг дэмжих шийдвэр гаргав.</p> <p>15.1 заалтад байх “сайтар бэлтгэсэн” гэсэн үгийг хасах.</p> <p><i>Шийдэл: Энэ үгийн утга Монгол хэл дээр хэрхэн орчуулагдсантай холбоотой зөрчил үүсэж байгааг ойлгосон. Ямар агуулгатай хэллэг болохыг орчуулагчид тодорхой болгож өгсөн.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал сэтгэлдэл ба тэдгээрт өгөх хариу, шийдэл
	<p>Заалт 18.3-ыг шаардлага бус сайжруулах үзүүлэлт болгох хэрэгтэй. Учир нь үүнийг хянахад амархан биш.</p> <p><i>Шийдэл: Хянахад амархан биш гэсэн нь тус шаардлагыг хасах сайн үндэслэл болохгүй гэж үзэж байна. Гэхдээ бид энэ асуудлыг аудитын үр дүнтэй уялдуулж хяналт тавин ажиллах ба дараа удаагийн үнэлгээнд хэлэлцэх асуудал болгож оруулах боломжтой.</i></p>
<p><b>Бусад</b></p>	<p>Олон оронд зориулсан олон дүрэм нь шударга бус байдалд хүргэж буй талаарх санал шүүмжүүд.</p> <p><i>Шийдэл: Суурь шалгуурууд яг ижил байгаа бөгөөд үүнийг баталгаажуулахыг хүсвэл үйлдвэрлэгч орнуудад зориулсан удирдамжтай өөрийн төрөлх хэл дээр уншиж танилцана уу.</i></p> <p>ТННЭ-ийн төсөөлөөгүй үр дүнгийн талаар бүртгэл хөтлөх нь компани, малчдын ажилтай ямар ч холбоогүй, чухал ач холбогдолгүй гэж үзэж байна.</p> <p><i>Шийдэл: Энэ асуудалтай холбогдох заалтыг Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлагад оруулав. Ингэснээр ТҮБ нь аудитын ажлын нэг хэсэг болгож энд дурдсан зүйлсийг судлах боломжтой болно. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгж нь бүртгэл хийхийн оронд ТҮБ-д энэ үүрэг оногдоно гэсэн үг.</i></p>





Хүснэгт 7: Стандартад өөрчлөлт оруулахад хүргээгүй санал сэтгэгдлүүд. Санал сэтгэгдэл тус бүрд хамаарах хариулт, үндэслэлийг тусгав.

Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
<p><b>Үр дүнтэй удирдлага</b></p>	<p>Заалт 6.1: Хортон шавж устгалын бодис, бордоо, болон бусад аюултай бодисын бүртгэл хөтлөлтийг малчид бус тэднээс дээд түвшний хүмүүс гүйцэтгэх хэрэгтэй. Малчдын хувьд бичиг цаастай холбоотой ажил хийх нь хүндрэлтэй.</p> <p><i>Хариулт: Энэ нь малчны үүрэг хариуцлага бус аж ахуйн нэгжийн хүлээх хариуцлага болно.</i></p>
	<p>Заалт 6.1 h) ба 6.1 j): Компани болон малчдын зүгээс энд заасан мэдээлэл нь тэдгээрийн ажилтай холбоогүй, бүртгэл хөтлөх нь ач холбогдолгүй гэж үзэж байна.</p> <p><i>Хариулт: Эдгээр заалтууд өмнө нь байсан заалтууд буюу нэмэлт ажил удаж буй асуудал биш юм. Хэрэв мэдээллийн нууцлалтай холбоотойгоор санаа зовниож байгаа бол ТҮБ нь тус бүртгэлтэй танилцах эрхтэй бөгөөд бусад талуудад хуваалцах шаардлага байхгүй болно.</i></p>
	<p>Заалт 6.2 c), d) ба e): Малчид энэ төрлийн мэдээллийг тэмдэглэж аваад байдаггүй. Ихэнхдээ бичиг үсэг тайлагдаагүй байдалтай холбоотой. Гэхдээ малчдаас амаар асууж тодруулбал тоо баримт хэлж чадна.</p> <p><i>Хариулт: Энэ талаар хэлэлцэж үзэх боломжтой.</i></p>
	<p>Олон нийтийн дунд явагдсан хэлэлцүүлгээс тогтмол сайжруулалтын схемийг дэмжиж байгаа нь харагдсан.</p> <p><i>Хариулт: Ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй.</i></p>
	<p>Малын гарал үүсэл/эцгийн бүртгэлийг хийх нь хэрэгцээгүй.</p> <p><i>Хариулт: Энэ нь шаардлага бус ердөө сайжруулах үзүүлэлт болно.</i></p>
<p><b>Зохистой хөдөлмөр эрхлэлт</b></p>	<p>Заалт 9.4: Мэдээлэл авах, гуравдагч талд дүн шинжилгээ хийх боломж олгох зорилгоор хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг цаасан дээр тусгасан байх саналыг оруулах.</p> <p><i>Хариулт: Үүнтэй уялдуулж ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй. Бичиг үсэг тайлагдаагүй/зохих боловсрол эзэмшээгүй ажилчдын эсрэг ашиглах боломжтой бичгээр үйлдсэн гэрээ үйлдэхгүй байх шийдвэрийг сайн бодолцсоны үндсэн дээр гарсан байдаг.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
<b>Зохистой хөдөлмөр эрхлэлт</b>	<p>Заалт 9.1.1: Энэ заалт нь гэр бүл дотор нэгнээ албан хүчээр хөдөлмөр эрхлүүлж болно гэсэн утгаар ойлгогдож байна. Гэхдээ бодит байдал дээр ингэх нь санаа зовоох асуудал биш байдаг.</p> <p><i>Хариулт: Бидний зүгээс ийм явдал тохиолдоно гэж үзэхгүй байгаа боловч энэ төрлийн үйлдэл тэмдэглэгдсэн тохиолдол үүнийг тэр даруй асуудал болгон хэлэлцүүлэх болно.</i></p>
	<p>"Аман хэлбэрийн гэрээ/тохиролцоо" (жишээ нь заалт 3.4 ба 9.4) гэсэн нь тодорхой бус, баталгаажуулах боломжгүй.</p> <p><i>Хариулт: Бидний зүгээс санал нийлэхгүй. ТҮБ нь гэрээнд тусгагдсан заалтуудын талаар хоёр талын хооронд хийгдсэн тохиролцоог үр дүнтэй аман тохиролцоо гэж үзэх боломжтой.</i></p>
<b>Биологийн олон янз байдал ба газар ашиглалт</b>	<p>12.3 ба 12.4 заалтуудыг нэгтгэх хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Заалт 12.3 нь байгаль хамгааллыг авч үздэг (шаардлага) бол заалт 12.4 нь нөхөн сэргээлтийн тухай (сайжруулах үзүүлэлт) юм. Иймд эдгээр заалтуудыг бие даасан тусдаа заалт хэвээр нь үлдээх хэрэгтэй гэж үзэж байна.</i></p>
	<p>Газар доройтох явдлыг багасгахын тулд малын тоо толгойг багасгах хэрэгтэй ба малын чанарыг сайжруулах хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Стандартад үүнийг тусгасан байдаг.</i></p>
	<p>Хөдөө аж ахуй эрхлэлт нь маш хүнд, сорилт ихтэй бөгөөд аюултай бодистой ажиллахыг шаарддаг.</p> <p><i>Хариулт: Аюултай бодисын хэрэглээг зогсоох, хориглох зүйл байхгүй байна.</i></p>
<b>Малын тавлаг байдал</b>	<p>Хашаалсан эсвэл байр сууцад оруулсан тохиолдолд бүх малыг тухтай хэвтэж амрах боломжоор хангаж хангалттай хэмжээний хуурай, зөөлөн, уян хатан дэвсгэр эсвэл ивээс бэлдэж өгөх хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Хувилбар 2.0 дахь холбогдох шаардлагуудыг шинэчлэх үеэр энэ заалт орхигдсон. Гэхдээ бид хувилбар 1.0-д байсан анхны шаардлагыг дахин авч багахан хэмжээнд өөрчилж шинэчилсэн стандартад оруулж өгсөн.</i></p>
	<p>Ухнад оногдох зохимжтой үржлийн харьцаа нь ухнын наснаас хамааралтай байна.</p> <p><i>Хариулт: Хувилбар 2.0 дахь холбогдох шаардлагуудыг шинэчлэх үеэр энэ заалт орхигдсон. Гэхдээ бид хувилбар 1.0-д байсан анхны шаардлагыг дахин авч багахан хэмжээнд өөрчилж шинэчилсэн стандартад оруулж өгсөн. Энэ шаардлагад тодорхой байдал дутмаг байгаа бөгөөд үүнийг дараа удаагийн хяналт, үнэлгээний үеэр авч хэлэлцэх болно.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
Малын тавлаг байдал	<p>Чөлөөтэй хөдлөх, гүйж харайх талбай нь гадаах задгай орчин байх хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Хувилбар 2.0 дахь холбогдох шаардлагуудыг шинэчлэх үеэр энэ заалт орхигдсон. Гэхдээ бид хувилбар 1.0-д байсан анхны шаардлагыг дахин авч багахан хэмжээнд өөрчилж шинэчилсэн стандартад оруулж өгсөн.</i></p>
	<p>Хөл хорио буюу тусгаарлалтыг сайжруулах үзүүлэлт бус шаардлага болгох хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Хувилбар 2.0 дахь холбогдох шаардлагуудыг шинэчлэх үеэр энэ заалт орхигдсон. Гэхдээ бид хувилбар 1.0-д байсан анхны шаардлагыг дахин авч багахан хэмжээнд өөрчилж шинэчилсэн стандартад оруулж өгсөн.</i></p>
	<p>Малын сэг зэмээр хооллодог зэрлэг золбин ноход их байна. Дахиж нэмэгдэж гарч ирсээр байдаг тул тэдгээрийг устгах нь үр дүнгүй байна.</p> <p><i>Хариулт: Зэрлэг золбин нохдыг устгах тухай шаардлага байхгүй болно.</i></p>
	<p>Монгол Улсад Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.4.3-т тусгаарлалт хийхтэй холбоотой хуулийн зохицуулалт байдаг. “Ямаан сүрэг хариулагч малчин нь үржүүлгийн бус үеэр эр ямааг сүргээс нь салгаж болохгүй” гэсэн заалтыг нэмэх.</p> <p><i>Хариулт: Стандартад “үржүүлгийн бус үеэр” гэж тусгасан байдаг.</i></p>
	<p>14.7 ба 14.4 заалтуудыг нэгтгэх хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Тусгаарлалт, хатуу хорих гэсэн нь хоёр ондоо зүйлийн талаарх заалтууд учир тусдаа хэвээр нь байлгах хэрэгтэй. Тухайлбал, хатуу хорилгүйгээр тусгаарлаж болох бол тусгаарлалтгүйгээр хатуу хорьж болно.</i></p>
	<p>Мал зулгааж идэхэд тохиромжтой бутлаг, сөөглөг ургамал бүхий газарт бэлчээрлэх боломжтой байх гэсэн сайжруулах үзүүлэлтийг шаардлага болгох хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Хувилбар 2.0 дахь холбогдох шаардлагуудыг шинэчлэх үеэр энэ заалт орхигдсон. Гэхдээ бид хувилбар 1.0-д байсан анхны шаардлагыг дахин авч багахан хэмжээнд өөрчилж шинэчилсэн стандартад оруулж өгсөн.</i></p>
	<p>16.13 ба 16.14 заалтуудыг нэгтгэх хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Бид тус заалтуудыг тусад нь үнэлэх хэрэгтэй гэж үзэж байна.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
<p><b>Малын тавлаг байдал</b></p>	<p>Зарим өрхүүд ямааны эврийг хуурайддаг.  <i>Хариулт: Энэ нь хүлээн зөвшөөрөгддөг; үүнтэй уялдуулж өөрчлөлт оруулах шаардлагагүй.</i></p>
	<p>Заалт 15.1: Туршлагагүй нь тогтоогдсон хүмүүст ямар арга хэмжээ авах, гэмтсэн малыг тодорхойлох шаардлагын талаар мэдээлэл байхгүй байна.  <i>Хариулт: Гэрчилгээг түр хугацаанд эсвэл бүр мөсөн хүчингүй болгоно. ТННЭ нь зарчмын үүднээс асуудалд хэрхэн хандах талаар нарийн зааварчилгаа өгдөггүй болно.</i></p>
	<p>Заалт 15.2: Малын тавлаг байдлыг хадгалахад одоогийн арга барил хангалттай гэж тодорхойлохоосоо өмнө тус стандартад болон аудиторын удирдамжид яг ямар арга барил хүлээн зөвшөөрөгдөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй.  <i>Хариулт: Одоо байгаа шаардлага нь малын тавлаг байдлыг хамгаалахад авч хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааг ойлгомжтой тусгасан гэж үзэж байна.</i></p>
	<p>Заалт 16.11-г сайжруулах үзүүлэлт бус шаардлага болгох хэрэгтэй.  <i>Хариулт: Энэ заалт нь сайжруулах үзүүлэлт хэвээр үлдэх ёстой. Үгүй бол авч хэлэлцэхийн аргагүй олон тооны шаардлага гаргахад хүргэж малчны хотноос гадуурх системд хүндрэл учруулах болно. Заалт 16.11 нь энэ мэт системийг “ТННЭ Шилдэг Туршлага” шаардлага хангахаас сэргийлэх хоёр шаардлагын нэг нь юм. Ямааны шим тэжээлийн хэрэгцээг хангах хангалттай хоол тэжээлийн талаар өөр шаардлага байдаг ба тэр нь “шаардлага” заадаг болохыг анхаарна уу. Үүнтэй адил саналд үндэслэж 16.10 заалтыг сайжруулах үзүүлэлт байсныг шаардлаа болгож өөрчилсөн.</i></p>
	<p>Хоол тэжээл дэх өвслөг ургамлын эзлэх хувийг тодорхой болгох хэрэгтэй.  <i>Хариулт: Эзлэх хувийг оруулж өгснөөр энэ шаардлагыг илүү үр дүнтэй болгоно гэж үзэхгүй байна. Гэхдээ зарим үүлдрийн хувьд үр нөлөөг өөрчлөх боломжтой болгох үүднээс энэ шаардлагыг илүү нарийн болгож болох юм.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
<p><b>Малын тавлаг байдал</b></p>	<p>Заалт 17.7-г сайжруулах үзүүлэлт бус шаардлага болгох хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Биет байршлууд нь малынхаа гарз хохирлыг хянах, үүнд хариу арга хэмжээ авахгүй байх нь маш ховор тохиолдол байх болно гэж үзэж байна. Учир нь мал сүрэг хорогдолтой байх нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Иймд энэ асуудалд өөрчлөлт оруулсан тохиолдолд аудит хийх нь цаг, хөрөнгө үрсэн хэрэг болох юм. Гэхдээ энэ нь аж ахуйн нэгжийн хүрээний сайжруулах үзүүлэлт бөгөөд аж ахуйн нэгжийг бүх биет байршлуудынхаа малын гарз хохирлыг үнэлэх хэрэгцээтэй болгодог тул үүнийг хэрэгжүүлснээр үр ашигтай байх үйл ажиллагаа болно гэдэгт итгэлтэй байна.</i></p>
	<p>Заалт 19.10-г сайжруулах үзүүлэлт биш шаардлага болгох хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Энэ тал дээр алдаа гаргасан байна. Угтаа бүх ямаа байгалийн гэрэлд гарах бололцоотой байх ёстой. Бид энэ заалтыг шаардлага болгож өөрчилсөн.</i></p>
	<p>Стандарт нь хориглох тодорхой шалтгаангүй тохиолдолд ямааг бэлчээрт гаргаж байхыг шаардах хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Үүнийг шаардлага болгох нь стандартад эрс өөрчлөлт оруулах бөгөөд олон тооны үйлдвэрлэлийн томоохон системүүдийг хөтөлбөрөөс халахад хүргэнэ. Заалт 19.1, 16.11 нь сайжруулах үзүүлэлтүүд бөгөөд хэдийгээр заавал мөрдөх албагүй ч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд (фермийн аж ахуй эрхлэлтийн системүүд үргэлж татгалздаг) тухайн аж ахуйн нэгжийг “ТННЭ Шилдэг Туршлага” хангасан гэж үзэх үндэслэлгүй болгоно.</i></p>
	<p>Стандарт нь малын эмчийг (болон малын эмчгүй орнуудад мал эмчилгээгээр мэргэшээгүй мэргэжилтнүүдийг) тодорхой үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг шаардах хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Стандарт нь итгэмжлэл, албан ёсны боловсролтойг нотлох нь боломжтой бүс нутгуудад тэдгээрийг шаардахаас зайлсхийж, оронд нь ур чадвар, туршлагатай байдлаа нотлохыг шаарддаг.</i></p>
	<p>Заалт 24.3-г сайжруулалт үзүүлэлт бус шаардлага болгох хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Биет байршлууд нь малынхаа гарз хохирлыг хянах, үүнд хариу арга хэмжээ авахгүй байх нь маш ховор тохиолдол байх болно гэж үзэж байна. Учир нь мал сүрэг хорогдолтой байх нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Иймд энэ асуудалд өөрчлөлт оруулсан тохиолдолд аудит хийх нь цаг, хөрөнгө үрсэн хэрэг болох юм. Гэхдээ энэ нь аж ахуйн нэгжийн хүрээний сайжруулах үзүүлэлт бөгөөд аж ахуйн нэгжийг бүх биет байршлуудынхаа малын гарз хохирлыг үнэлэх хэрэгцээтэй болгодог тул үүнийг хэрэгжүүлснээр үр ашигтай байх үйл ажиллагаа болно гэдэгт итгэлтэй байна.</i></p>



Зарчим	Ирүүлсэн санал, сэтгэгдэл ба ТННЭ-ийн зүгээс өгсөн хариулт
	<p>Стандарт нь бэлчээрт идээшлүүлэхийг нэмэлт тэжээлээр хооллохоос илүүд үзэх ёстой.</p> <p><i>Хариулт: Тус саналыг гаргасан хүн ургамлын шим тэжээл буюу бэлчээрийн ургамлыг нэмэлт тэжээлтэй андуурсан байх гэж үзэж байна. Нэмэлт тэжээлээр хооллохоос илүү бэлчээрт идээшлүүлэхийг стандартад илүү үздэг.</i></p> <p>Стандарт нь үржлийн бус үед ухныг сүргээс тусад нь байлгахыг шаардах хэрэгтэй.</p> <p><i>Хариулт: Бусад оролцогч талуудын санал сэтгэгдэл байр сууринаас харвал бид үүнтэй санал нийлэх боломжгүй байна.</i></p>
<b>Бусад</b>	<p>Стандарт, туршлагад суурилах бус ондоо аргачлалаар мал малласан тохиолдолд энэ тухайг тэмдэглэх хэрэгтэй ба ингэснээр аудиторуд тус аргачлалыг ашиглаж болох туршлага мөн эсэх, эсвэл фермтэй холбоотой асуудал/үл ойлголцол байгаа эсэхийг тодорхойлж чадна. Энэ нь цаашлаад малын тавлаг байдал, өсөлтийг нэмэгдүүлэхэд тогтмол сайжруулалт хийх, сургалт авах, илүү сайн удирдлагатай болох зэрэг шаардлагатай талуудыг гаргаж ирэх бөгөөд стандартад мөрдлөг болгох амлалтаа биелүүлэх, хэр үр дүнтэй болохыг харуулах боломжийг бүрдүүлнэ.</p> <p><i>Хариулт: ТННЭ Баталгаа, гэрчилгээжүүлэлтийн гарын авлагад аудиторудыг стандартад тусгагдсанаас бусад үйл ажиллагаа явуулсан тохиолдолд тэмдэглэл хийхийг шаардсан байдаг.</i></p> <p>Олон нийтийн хэлэлцүүлэг нь аж ахуйн нэгжүүдийг хөтөлбөрөөс гаргахад хүргэх өөрчлөлттэй холбоотой ямар нэг асуудлыг тогтоогоогүй.</p> <p><i>Хариулт: Ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй.</i></p> <p>Олон нийтийн хэлэлцүүлгийн явцад шинэчилсэн стандарт нийтлэгдсэнээр анх удаагаа гэрчилгээ авахаар хүсэлт гаргах шинэ аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэнэ гэсэн хүлээц байгаа болох нь харагдсан.</p> <p><i>Хариулт: Үүнтэй уялдуулж ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй.</i></p> <p>Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд шинэчилсэн стандартын агуулга, төвөгшилтэй холбоотой ямар нэг асуудал дэвшигдээгүй.</p> <p><i>Хариулт: Ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй.</i></p>